

УЛС ТӨР

С.ЭРДЭНЭ: ТӨРИЙН АЛБАН
ХААГЧДЫГ ТӨРӨЛ БҮРЭЭР
ДАРАМТАЛЖ БАЙГАА

II нүүрт

УЛС ТӨР

ХАН-УУЛЧУУД МОНГОЛ УЛСЫН ТАВ
ДАХЬ ЕРӨНХИЙЛӨГЧ “АЖИЛЧНЫ
РАЙОН”-ООС ТӨРНӨ ХЭМЭЭЛЭЭ

IV нүүрт

Улаанбаатар: ӨНӨӨДӨР



Дугаарын **60** мөр

Сонгуульдаа
идэвхтэй
оролцоорой

Н.БАТЗАЯА

Монгол Улсад амьдрах арга алга гэж олон хүн ярьдаг. Ганц удаа ч болов би орчин тойрноо өөрчлөхөд юу хийж чадах вэ гэж бодож үзсэн үү. “Таны Монгол Улсын хөгжилд оруулж чадах хамгийн том хөрөнгө оруулалт юу вэ” гэх асуултад хүн бүр өөр өөрийнхөөрөө хариулна. Магадгүй зарим нэг нь энэ асуултад би хэт өндөр боловсролтой биш, би мөнгөгүй, би эрх мэдэлгүй учраас том хөрөнгө оруулалт хийж чадахгүй гэх биз. Танд ямар ч эд хөрөнгө, эрдэм боловсрол, эрх мэдэлтэй зүйрлэлгүй том хөрөнгө оруулалт бий. Тэр бол Үндсэн хуулиар олгогдсон таны сонгох эрх. Автобусанд эсвэл гудамжинд гээд хаа нэгтээ “Сонгуульд саналаа өгөхгүй. Миний саналаар дутахгүй” гэх яриа өрнөх нь энгийн үзэгдэл мэт болжээ. Эсвэл гурвууланг нь дугуйлна, хоосон өгнө гэх мэтээр бусдыг уриалсан санал ч олны танил хүмүүсээс гарах аж. Тэр тусмаа залуучуудын дунд энэ мэт өөрийн саналыг үнэгүйдүүлсэн сөрөг яриа их гарч байгаа сонсогддог. Монгол Улсын хөгжлийг гартаа атгасан хүн бол хэн нэгэн улс төрийн зүтгэлтэн бус зөвхөн та. Өөрөөр хэлбэл, таны сонголтоос бүх зүйл шалтгаална гэсэн үг. Дээхэн үед хүмүүс саналаа өгөхөөр явахдаа хамгийн сайхан хувцасаа өмсч, өвөө эмээ нар одон медалиа зүүдэг байсан гэх сайхан түүх бий. Одоо ч гэсэн настан буурлуудын дунд энэхүү сайхан уламжлал үргэлжилсэн хэвээр.

Үргэлжлэл нь III нүүрт

АМЖИЛТЫН ЭЗЭД



Н. ТУВШИНБАЯАР:

Гэрэл зургийг Г.АРИУУЖИН

**БИ ҮНДЭСНИЙ БӨХӨӨ ДЭЛХИЙ ДАХИНД
СУРТАЛЧЛАХ ГЭЖ БАРИЛДДАГ**

Н.ПУНЦАГБОЛД

Монгол Улсын Гавьяат тамирчин,
Хөдөлмөрийн баатар, Олимпын наадмын

алт, мөнгөн медальт Н.Тувшинбаяртай
ярилцлаа.

Үргэлжлэл нь VI нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

ХЭН ЮУ ХЭЛЭВ

Г.ГАНЧИМЭГ

Л.Гантөмөр: Бид хоцрогдсоноо хүлээн
зөвшөөрөх хэрэгтэй

/БСШУ-ы сайд асан/

Бид хоцрогдсон орон гэдгээ хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Монголын эдийн засгийн хэмжээ Японы нэг сумын эдийн засагтай тэнцүү гэдгийг ойлго. Ялгаа бий. Энэ ялгааг яаж бий болгов гэхээр асар өндөр технологийг эзэмшсэн байна. Үүнийг гүйцэхийн тулд хамт байх ёстой. Эндээ юмаа хийгээд байвал бид цаг алдана. Цаг алдаад байвал байгаль биднийг сөхрүүлчихнэ шүү дээ. Байгалийн доройтлогтой зэрэгцүүлэн өндөр технологи нэвтрүүлж байж дэлхийтэй өрсөлдөнө гэдгээ анхаарах ёстой. Манайхан дэлхийтэй өрсөлдөнө гэхээр “Үгүй ээ, тэр худал” гэдэг. Өрсөлдөнө. Саяхан Тайвань, Сингапур, Солонгос ямар байлаа. Бусдад байгаа боломж бидэнд ч бий. Бодлого нь зөв байвал гараад л ирнэ.

Үргэлжлэл нь III нүүрт

НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ

**15 мянган иргэн “Хөдөлмөрийн бирж”-ээр
үйлчлүүлснээс 2000 нь ажилтай болов**



Гэрэл зургийг Г.АРИУУЖИН

Б.ӨНӨР

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны нээлттэй хаалганы өдөрлөг энэ сарын 19, 20-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулагдаж өндөрлөсөн. Өдөрлөг хоёр өдөр үргэлжлэх хуваарьтай байсан ч хоёр дахь өдөр нь цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалж үйл ажиллагаагаа төлөвлөгөөнийхөө дагуу Сүх-

баатарын талбайд явуулж чадаагүй юм. Гэсэн хэдий ч иргэдийнхээ хүсэлтийн дагуу яамныхаа байранд иргэдийг хүлээн авч уулзан, тэднийг ажилд зуучлах үйл ажиллагаагаа үргэлжлүүлсэн билээ. Тус нээлттэй хаалганы өдөрлөг нь ганцхан нийслэл хотод зохион байгуулагдаагүй гэдгээрээ илүү онцлогтой юм.

Үргэлжлэл нь V нүүрт

МОНГОЛЫН МЭДЭЭ

Манай сонины III улирлын захиалга үргэлжилж байна

Улиралд **44** дугаар

Захиалгын үнэ **19800**



Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай post: 70121294
Түгээмэл шуудан: 70115025

ХААН банк	Хуудалгаа хөгжлийн банк			
	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2355.00	2369.00	ФУНТ	2948.00
ЕВРО	2609.00	2659.00	РУБЛЬ	38.40
ИЕН	21.11	21.42	ЮАНЬ	343.50

УЛС ТӨР

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

С.ЭРДЭНЭ: ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫГ ТӨРӨЛ БҮРЭЭР ДАРАМТАЛЖ БАЙГАА



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

Б.ЭРХЭС

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшигч Х.Баттулга болон Ардчилсан намын дарга С.Эрдэнэ нар өчигдөр Төрийн ордонд сэтгүүлчдэд мэдээлэл хийлээ. Тэд Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаа дуусах хугацаа дөхсөн учраас цаг үеийн асуудлаар мэдээлэл өгсөн юм. Ардчилсан намын дарга С.Эрдэнэ “Ерөнхийлөгчийн сонгууль болоход цөөхөн хэдхэн хоног үлдлээ. Сонгуулийн сурталчилгааны хугацаа богино байсан ч АН-аас нэр дэвшигч

маань 12 хоногт 21 аймаг, 20 сум, дөрвөн тосгоноор орж иргэд сонгогчид тоогоо уулзлаа. Бид илт тэнцвэргүй сонгуульд өрсөлдөж байгааг хэлэх нь зөв болов уу. АН-ын явуулсан мэдээ, мэдээллийг нэвтрүүлсэн хэвлэл мэдээллийн байгууллага, түүний сэтгүүлчдийг төрийн нэрээр сүрдүүлж, дарамтлах, торгох, эрүүгийн хэрэг үүсгэх асуудал хэрэв хэтэрч байна. Бидэнд ирсэн мэдээллээр сүүлийн өдрүүдэд АН-ын мэдээ, мэдээллийг цацсан гэдгээр 30 гаруй хэвлэл мэдээллийн байгууллагад мэдэгдэл хүргүүлж, цагдаад дуудаж байцаасан байна. АН-ын хэвлэл мэдээллийн байгууллага ч байцаалтад орсон. Үүнийг бичсэн сэтгүүлчийг гэрээс нь баривчлах оролдлого хийх, цагдаагийн албан хаагчар байцаалгах, эрүүдэн шүүх зэргээр дарамталж байгаад харамсч байна. Монголын Ардчилсан намын даргын хувьд би маш их эмзэглэж байна. Мөн эрх баригч намын 60 тэрбумын наймааг илчилсэн залууг хамгаалах нэрээр 60 цагдаагаар бүсэлж, сэтгэлзүйн дарамт учруулсан. Ардчилсан Монгол Улсад байж болохгүй үйл ажиллагаа явуулж байгаа. Сонгуулийн ухуулах байруудаар цагдаанаар явж үндэслэлгүй хэрэг үүсгэх, ухуулах хуудас хурааж авах зэргээр байж боломгүй үйл явдал тоогоо алдлаа. Шулуухан хэлэхэд, нийгмийн тогтвортой байдлыг хангах учиртай цагдаа нар улс төрийн хүчний нохойд барьдаг мод шиг ажиллаж байгаад харамсч байгаа. Гэхдээ энэ хүнд нөхцөлд манай намын нэр дэвшигч шантралгүй сурталчилгаагаа хийж, иргэдтэйгээ уулзаж

байна. Рейтинг өндөр байгаа нь сүүлийн үеийн олон судалгаанаас харагдаж байгаа” гэв. АН-ын зүгээс тодорхой асуудлаархуулийн байгууллагад хандсан ч нэг ч асуудалд эрүү үүсгээгүй байгаа аж. 60 тэрбумын асуудлыг хүртэл нэр дэвшигч Х.Баттулга өөрөө АТГ, Тагнуулын Ерөнхий газарт шалгуулахаар өгсөн байхад түүнийг шалгаагүй атлаа энэ асуудлыг бичсэн, мэдээлэх үүргээ гүйцэтгэсэн хэвлэл мэдээллийн байгууллагыг шалгах, цагдах, эрүү үүсгэх зэргээр дарамталж байгаад үнэхээр гайхаж байна гэдгээ С.Эрдэнэ дарга энэ үеэр онцоллоо. Төрийн эсрэг онц ноцтой гэмт хэргийн бүрэлдэхүүн үүсчихээд байхад хууль хяналтын байгууллага гараа хөдөлгөхгүй байгаа нь улс төрийн эрх ашиг гэдэг нь тодорхой байгааг ч энэ үеэр хэлж байсан юм. МАН-аас Үндсэн хууль болон бусад хуулийг ноцтой зөрчиж төрийн эрх мэдлийг авч, Сонгуулийн хуулийг ноцтой зөрчсөн асуудлыг эрээ цэвэргүй явуулж байгаа аж. Иргэдийн регистрийг авах, төрийн албан хаагчдыг дарамтлах, санал өгсөн хуудсаа заавал гар утсаар зургийг нь авч тайлагнах гэх мэтээр төрөл бүрээр дарамталж эхэлжээ. Маш олон аймаг дүүргийн уулзалтад төрийн албан хаагчдыг хүчээр ачиг хүргэж байгаа бөгөөд уулзалтад оролцохгүй бол ажилгүй гэж мэдээрэй хэмээн дарамтлах, ах дүү нарынхаа регистрийг авчрахыг шаардах, сонгуулийн штабад ажиллаж байгаа иргэдээ 20-30 регистрийн дугаар цуглуулж ирээд цалингаа ав гэх мэтээр

шат бүртээ тэд төрийн эрхийг хууль бусаар авах оролдлого хийж, иргэдийг ч буруу зүйлд турхирч байгааг хэвлэлийн хурлын үеэр мэдэгдлээ. Мөн Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч М.Энхболдын УИХ-ын сонгуулийн дараанамь нудархад албан тушаалтан, хууль шүүхийн байгууллагын дарга нартай баяраа тэмдэглэж буй бичлэг цахим орчинд цацагдсаныг АН-ын дарга онцлов. Тэрбээр, “Энэхүү бичлэгийг дахиад эвлүүлж хэмээн мэлээхгүй биз. Хэвлэл мэдээллийн байгууллага анхааралдаа авах байлгүй. СЕХ-ны дэд дарга н.Болдсайхан нарын хооронд сонгуулийг луйвардсан байж болох ноцтой зүйл яригдаж байгаа. Сонгууль болоо биз дээ. Сонгууль хийсэн биз дээ гэж инээгээд байгаа байхгүй юу. Юу гэсэн үг вэ. Хэдийгээр тоглоом юм шиг ярьж байгаа ч цаад утга нь маш ноцтой. Энэ асуудлыг МАН-ынхан тайлбарлахыг бид шаардаж байна. Энэ бүхнийг манай нам гаргаж тавиагүй. Ардчилсан Монгол Улсаа хамгаалах гэсэн иргэд л энэ бүхнийг гаргаж байгаа. Холбогдох баримт гаргаад тавихаар харлуулж байна, гүтгэж эхэллээ гэх мэтээр хариуцлагаас зугтах юм. Дөрөвдөх засаглал хаашаа орсон бэ. Бүгд хаалтын гэрээ байгуулчихаж. Монгол Улсын тусгаар тогтнолыг зарах тухай ярьж байхад хэвлэл мэдээлэл амаа үдүүлсэн мэт дуутгүй байна. Хэвлэл мэдээллийн эрх чөлөө байхгүй болж байгаа нь монгол төрийн дархлаа байхгүй болсныг илтгэжээ. Би хэвлэл мэдээлэлд хүндэтгэлтэй хандаж ирсэн. Цаашдаа ч тэгж ажиллана” гэв.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Ч.Өнөрбаяр зөвлөх Оксфордоод зочин профессороор уригджээ

Ерөнхийлөгчийн хүний эрх, хуулийн бодлогын зөвлөх, хууль зүйн ухааны доктор Ч.Өнөрбаяр Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, гишүүд, ажлын алба өчигдөр хүндэтгэл үзүүллээ. Ч.Өнөрбаяр зөвлөх Оксфордын их сургуулийн урилгаар зочин профессороор ажиллахтай нь холбогдуулан ийнхүү хүндэтгэл үзүүлж буй юм. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, доктор, профессор Н.Лүндэндорж хэлсэн үгэндээ “Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилж эхлүүлсэн шүүхийн шинэтгэлийн төлөөх нөр их хөдөлмөрөө Ч.Өнөрбаяр зөвлөх тур завсарлуулж байна. Энэ хугацаандаа Их Британи улс дахь Оксфордын их сургуульд зочин профессороор ажиллахаар болсон нь сайхан мэдээ юм. Улс төрийн ажлаа завсарлаж, дэлхийн сод сургуульд зочин профессороор ажиллах хувь тохиол тэр бүр хүнд тохиохгүй. Шүүхийн шинэтгэлийн том хөдөлгөөнийг бид маш хүнд цаг үед хийсэн. Энэ хүнд цаг үеийг хамтдаа туулж, том өмөг түшиг

болон шүүхийн шинэтгэлийг үр дүнд хүргэхэд Ч.Өнөрбаяр зөвлөхийн оруулсан хувь нэмэр их. Ч.Өнөрбаяр маань Монгол Улсын Ерөнхийлөгчийн итгэлийг олж ажиллалаа. Хүний итгэлийг олох ухаан, хүн чанарын асуудал байдаг” гэж онцлов. Харин Ч.Өнөрбаяр зөвлөх талархаж буйгаа илэрхийлээд “Шүүхийн шинэтгэлийн үзэл санааны тулгын чулууг тавьсан хүн бол профессор Н.Лүндэндорж багш. Тэр үзэл санааг биежүүлж, ажил болгох нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал, санаачилга байсан. Шинэтгэлийг амьдралд хэрэгжүүлэхэд Шүүхийн ерөнхий зөвлөлийнхөн, шүүхийн хамт олон бүгд хүчин зүтгэсэн гэдгийг онцолъё. “Шүүхийн шинэтгэлийн төлөө хамтдаа” гэсэн уриа, үнэт зүйл, зарчимд нэгдсэн бүх хүн шинэтгэлийг хийсэн. Энэ бол эхлэл. Цаашид эхлүүлсэн ажлаа илүү чамбайруулах ёстой. Би залуу хүн. Монголын төрд хүчин зүтгэнэ. Хийж бүтээхээр бодож, санасан зүйл ч их бий” гэсэн юм.

С.Мөнхчулуун: АН-ын сонгуулийн штаб гүтгэлэг тарааж байна

Нийслэлийн МАН-ын сонгуулийн штабаас өчигдөр сэтгүүлчдэд мэдээлэл хийлээ. Нийслэлийн МАН-ын хорооны дэд дарга С.Мөнхчулуун “Ардчилсан намын сонгуулийн штабын зүгээс хууль бус сурталчилгааг маш ихээр хийж байна. Сонгуулийн хуулиар хэвлэл материалд нэр дэвшигчдийн



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

мөрийн хөтөлбөр, намтар, тайлан байна гэж заасан байдаг. Гэтэл Ардчилсан намын сонгуулийн штаб хар PR материал нийтэлж, мөнгө тарааж байгаа талаар бидэнд мэдээлэл ирсэн. Түүний нэг нь Баянзүрх дүүргийн 21 дүгээр хороонд эд зүйл тараахаар бэлтгэсэн талаарх утсаар ярьсан бичлэг байна. Тус дүүргийн 21 дүгээр хорооны хэсгийн ахлагч н.Тунгалаг гэдэг хүн иргэд рүү ярьж, иргэний үнэмлэхээ авчир, мөнгө өгье гэсэн бичлэг бидэнд байгаа. Мөн Сүхбаатар, Чингэлтэй дүүрэгт гурил, будаа тараахаар бэлтгэж байна. Нэг хүний иргэний үнэмлэх авчирвал 50 мянган төгрөг, таван хүний иргэний үнэмлэхийг 100-500 мянган төгрөгөөр худалдан авч байгаа тухай мэдээлэл маш их ирлээ. Бид хууль хяналтын байгууллагаар энэ бүхнийг шалгуулаа. Сонгуулийн сурталчилгааны хугацаанд хийсэн бүтээсэн, хийх зүйлээрээ шударгаар өрсөлдөхгүй хуулийг уландаа гишгэж байгаад харамсаж байна. Шударгаар өрсөлдөхийг өрсөлдөгч намууддаа уриалж байна. Төрийн тэргүүнээ сонгох сонгуульдаа санал өгөхдөө мөнгөнд хууртагдахгүй байхыг сонгогчдоодоо уриалж байна гэлээ. Тиймээс энэ мэт асуудлыг хууль хяналтын байгууллагаар шалгуулаа” гэв.

С.Ганбаатар тавилттай жүжиг хууртагдсан гэв

МАХН-ын Удирдах зөвлөлийн гишүүн Ц.Шаравдорж, нарийн бичгийн дарга Б.Тулга нар хэвлэлийн хурал хийлээ. Тэд олны анхаарал татаж буй МАХН-ын нэр дэвшигч С.Ганбаатар БНСУ-ын иргэнээс 50 сая авч буй бичлэгийн талаар “Тавилттай жүжигт хууртагдсан” гэж мэдэгдлээ.



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

Тодруулбал, МАХН-ын Удирдах зөвлөлийн гишүүн Ц.Шаравдорж “С.Ганбаатар Өмнөд Солонгосын иргэнээс 50 сая авсан байна гэж хэвлэлээр шуугиж байна. С.Ганбаатар хууль зөрчиж, хандив аваагүй. Яригдаад байгаа асуудал бол цэвэр зохион байгуулалттай гэмт хэргээ. Монголын улстөрчид сонгуульд гарч ирэхийн тулд гадаадын улс орон, гадаадын иргэдийг татан оролцуулдаг болжээ. Энэ нь улс орны тусгаар тогтнолд нөлөөлнө. Хандив өгсөн гэх Ван Сү-гийн талаар хэн ч мэдэхгүй байна. Сонгуулийн ерөнхий хороо /СЕХ/ түүнийг гэнэт гаргаж ирсэн. Гадны хүн яагаад Монголын улстөрд оролцож байна вэ гэдэг нь гайхшрал төрүүлж байна. Үнэхээр 50 сая авч өгсөн бол тэр хүн өөрөө ч гэмт хэргээ холбогдоно. Иргэнээ тагнаж, чагнах нь хэвийн үзэгдэл боллоо. Өмнөд Солонгосын иргэн Ван Сү-г ашиглахын тулд улстөрчид их зүйлийг боловсруулж, зохион байгуулсан байна. СЕХ улс төрийн захиалааг ажиллаж байна” гэв. Харин “Нэр дэвшигч С.Ганбаатар 50 сая авсан нь үнэн юм уу, эсвэл хандив аваагүй байхад СЕХ “түгээд байна” гэж та бүхэн хэлж байгаа юм уу” гэсэн сэтгүүлчдийн асуултад “Авсан гэж хэлээд байгаа тэр үйл ажиллагааг зохион байгуулалттай гэмт хэргээ гэж үзэж байна” гэж хариулсан юм. Тэгвэл ЦЕГ-аас иргэдээс ирсэн гомдлын дагуу нэр дэвшигчийг шалгаж эхэлсэн гэж мэдэгдлээ.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158**

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ 90873012**

Ахлах редактор: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: **Н.ПУНЦАГБОЛД 88096454**

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Гэрэл зургийн алба: **Г.АРТУУЖИН 96017873**

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ 99998796**

Маркетинг, зар сурталчилгааны алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710**

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ 99042510**

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн **Б.ӨНӨРТОГТОХ**

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: **Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот**

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ОНЦЛОХ МЭДЭЭ

2.3 мянган тонн махыг иргэдийн хэрэгцээнд хямд борлуулжээ

“Мах, сүүний анхдугаар аян”-ыг хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, стратегийн хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах, жигд хүртээмжтэй хангах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх юм. Энэ зорилтын хүрээнд өвөлжилт хүндэрсэн орон нутгаас мал, мах бэлтгэлийг нэмэгдүүлэх арга хэмжээг үйлдвэр, зориулалтын зоорь бүхий аж ахуйн нэгжтэй хамтран зохион байгуулжээ. Хөгжлийн банк, арилжааны банкаас 12 үйлдвэр, аж ахуйн нэгжид олгосон нийт 63.4 тэрбум төгрөгийн зээлийн хүүд хөнгөлөлт үзүүлж, 15.8 мянган тонн махыг хаврын улиралд иргэдийнхэрэгцээнд худалдаалж байна. Мах, сүүний анхдугаар аяны хүрээнд бэлтгэсэн махыг өнгөрөгч дөрөвдүгээр сард зах зээл дэх үнээс үхрийн махны үнийг 2195 төгрөг буюу 38.2

хувиар, хонины махны үнийг 1440 төгрөг буюу 26.7 хувиар, ямааны махны үнийг 425 төгрөг буюу 9.7 хувиар тус тус хямд үнээр борлуулжээ. Махны худалдааг нийслэлийн зургаан дүүрэгт 118 дэлгүүрээр, Дархан-Уул аймагт 118 дэлгүүрээр, Эрдэнэт хотод зургаан дэлгүүрээр иргэдийн хэрэгцээнд нийлүүлжээ. Мөн “Мах, сүүний анхдугаар аян”-ын хүрээнд махны өргөтгөсөн худалдааг нийслэлийн Хархорин, Орхон, Жуков, Тэнгэр, Нарантуул, Дунжингарав, Шар хадны эцэс, Хангай хотхон, 32-ын тойрог, Хороолол зах, Яармагийн эцэс, Баянхошуу, Цамбагарав, Содон хороолол, Шөнгийн зах, Хүчит шонхор, Нарантуул-2, Хан-Уул үйлчилгээний төв, Драгон, Энхжин, Сапоро, Миний дэлгүүр зэрэг байршил, газарт зохион байгуулсан аж. Өргөтгөсөн худалдаагаар үхрийн махыг 5200 төг/кг,

хонины махыг 4100 төг/кг, ямааны махыг 3800 төг/кг өөр тус тус борлуулсан. Энэ арга хэмжээний дүнд өчигдрийн байдлаар махны худалдааны гол төв болох “Хүчит шонхор зах” дээр бөөний үнэ хонины гулууз мах 1 кг нь 4100-4200 төгрөг, үхрийн өрөөл мах 1 кг нь 5200-5400 төгрөг, ямааны гулууз мах 1 кг нь 3800 төгрөг болж махны үнийг тогтворжуулаа. Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын хаврын улирлын хэрэгцээнд тогтоосон үнээр буюу зах зээл дэх махны үнээс 10-30 хувь хямд үнээр хэрэглэгчдэд нийлүүлж эхэлсэн махны үнийг тогтворжуулж, хаврын улиралд махны хомсдол үүсэхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн аж. Өчигдрийн байдлаар “Мах, сүүний анхдугаар аян”-ы хүрээнд нийт бэлтгэсэн махны 80 шахам хувь буюу 12.3 мянган тонн махыг худалдан борлуулаад байна.

ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын **60** мөр

ХЭН ЮУ ХЭЛЭВ



хөгжинө. Гэхдээ жуулчдыг татахад төмөр зам болоод агаарын тээврийн асуудалд онцгой анхаарах ёстой. Олон км газар VIP зэрэглэлээр явж байгаа хэр нь суудал нь ор болдоггүй, босоогоороо зорчих, онгоц нь жижиг гэх мэт асуудлууд гардаг. Дэд бүтцийн салбарыг хөгжүүлэхгүйгээр гадаадын жуулчид олноороо ирэхгүй юм билээ. Тиймээс тохилог хурдны галт тэрэгтэй болох, зундаа томоохон онгоц нойтон түрээсээр авах, найдвартай тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийг бий болгох шаардлагатай.

Л.Энхтайван:
Татварын орчин тодорхой, тогтвортой байх ёстой

/Эдийн засгийн ухааны доктор, профессор/

Татварыг ойр ойрхон хөдөлгөх бус аль болох тогтвортой байлгах ёстой. Гэтэл манай улс сүүлийн 10 гаруй жилд эдийн засгийн нөхцөл гайгүй болохоор янз бүрийн амлалт, популист бодлого хэрэгжүүлээд, татварыг бууруулчихдаг. Эргээд эдийн засгаа хэцүүдэхээр татвар нэмэгдүүлэх бодлого барьдаг. Нэгэнт бууруулчихсан татварыг буцааж нэмнэ гэдэг амархан биш. Энэ бол буруу жишиг. Хөрөнгө оруулагчид ирээдүйгээ 10-20 жилээр харж төлөвлөдөг. Тиймээс татварын орчин ямар байх вэ гэдэг нь тодорхой байх ёстой. Нөгөөтэйгүүр, татваруудыг нэмж байгаа нь үнэндээ шинэ зүйл биш. Өмнөх Засгийн газрын үед ч бас хэд хэдэн удаа татварын өөрчлөлтүүдийг

УИХ-аар хэлэлцүүлж байсан. Хадгаламжийн хүүгийн орлого, хүн амын орлогын шатлалт татварын тогтолцоо гэх зэрэг. Ер нь тэгээд энэ татварын нэмэгдлүүд хүн амын 95 хувьд нь нөлөөлөхгүй. Харин чинээлэг таван хувьд нь тодорхой хэмжээнд нөлөөлнө. Гэхдээ тэр хүмүүсийн амьжиргаа бизнест хүндрэл учруулахгүй.

Б.Билэгт: Эдийн засаг богино хугацаанд сэргэвэл хэвийн байдалдаа орно

/УИХ-ын гишүүн/

ОУВС-гийн хөтөлбөрт хамрагдахын тулд долоон өөрчлөлтийг хүч түрэмгийлсэн, аргагүйн эрхэнд гэдэг байдлаар гаргасан. Түүнээс л алдаа гараад ирж байгаа юм. Гэтэл тэр хооронд "Приус" машин нааш ачуулчихсан, замд явж байгаа хүмүүс хохирох болчихно. Тавдугаар сарын 1-нээс хууль хэрэгжих гээд байдаг. Замд явж байсан машинууд ороод ирэхээрээ тодорхой хэмжээний хохиролтой болчихож байгаа биз. Анхнаасаа л тодорхой хугацаа өгөх байсан юм. Гурван сарын хугацаатай байхад л бараагаа захиалах эсэхээ төлөвлөчихнө шүү дээ. Тиймээс хугацаан дээр гаргасан алдаагаа зассан. Долоон татварын өөрчлөлтөөс гадна хүүхдийн мөнгө гэх мэт зүйлс бас бий. Эдгээрийг эдийн засаг богино хугацаанд сэргэвэл буцаагаад хэвийн байдалд оруулах ёстой. ОУВС-гийн хөтөлбөрөөс манай улс гарчихвал буцаад хэвийн байдалд нь оруулна. Үүнийг 2019 он гэхэд хэвэнд оруулна байх гэж найдаж байгаа.

Сонгуульдаа идэвхтэй оролцоорой

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Гэвч манай улсын иргэдийн сонгуулийн идэвх жил ирэх тусам буурч байгаа нь олон судалгаанаас харагддаг. Тухайлбал, Монголчууд 1993 оны Ерөнхийлөгчийн сонгуульд 92.7 хувийн ирдэгтэйгээр оролцож байжээ. Энэ бол маш өндөр тоо. Харин 1997 онд сонгогчдын ирдэг 85.06, 2001 онд 82.94, 2005 онд 74.3, 2009 онд 73.59, 2013 онд 66.50 хувийн ирдэгтэй оролцсон байна. Уг судалгаанаас харахад сонгуульд саналаа өгөх иргэдийн оролцоо 26.2 хувиар буурчээ. Дөрвөн хоногийн дараа Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль орон даяар өрнөнө. Сонгуулийн бэлтгэл ажил ч жигдэрч байна.

Энэ жил сонгуулийн бэлтгэл ажилд зориулж 14 тэрбум 900 сая төгрөг төсөвлөсөн билээ. Өөрөөр хэлбэл, энэхүү мөнгө өөрийн биеэр сонгуулийн байранд очиж саналаа өгч чадахгүй ахмад настнуудыг зөөх машины шатахууны зардал, сонгуулийн штаб, хар машиныг 21 аймагт зөөх тээврийн зардал гэх мэтчилэн зүйлд зарцуулдаг. Зөвхөн таныг сонгуульд идэвхтэй оролцуулж, санал өгүүлэхийн тулд улсын төсвөөс ийм хэмжээний мөнгө гаргадаг гэсэн үг. Хэрвээ хэн нэгний санал

сонгуульд огт хэрэггүй, ямар ч ач холбогдолгүй бол Үндсэн хуульд сонгох эрхийг тусгаж, жил бүр улсын төсвөөс мөнгө гаргахгүй байсан биз. Таны санал улс эх орны ирээдүйн хөгжилд хэрэгтэй учраас, таны санал үнэ цэнэтэй учраас Сонгууль болгоноор улсын төсвөөс мөнгө гаргаж, орон даяар зохион байгуулдаг юм. Тиймээс энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгуульд хариуцлагатай хандаж, хүн бүр саналаа өгөхийг уриалж байна. Учир нь бүх ард түмний эв нэгдлийн билэгдэл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн, Зөвсэгт хүчний ерөнхий командлагчийг сонгох түүхэн, хариуцлагатай үе ирээд байна. Мөн Монгол Улсын өрийн хэмжээ, ядуурал, ажилгүйдэл ихэсч, улс орны эдийн засаг туйлдаа хүрсэн гэхэд болно. Тухайлбал, нэг хүнд ногдох өрийн хэмжээ 12 сая хоёр давчихаад байна. Шинээр төрсөн хүүхэд бүр энэ хорвоод мэндэлсэн цагаасаа эхлэн өрийн дарамтад орох болжээ. Нийгмийн орой бусгай цагт болж буй сонгуульд таны оролцоо хамгийн чухал. Тиймээс хүн бүр зургадугаар сарын 26-нд болох Ерөнхийлөгчийн сонгуульд идэвхтэй оролцохыг уриалж байна. Таны санал Монгол Улсын хөгжилд оруулах хамгийн том хөрөнгө оруулалт юм.

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Ц.Цэнгэл: "Цайны зам" –ын гурав дахь уулзалт манай улсад болно

/БОАЖА-ны Төрийн нарийн бичгийн дарга/

БНХАУ-ын санаачилсан "Нэг бүс-нэг зам" бол дэлхийн улс орнуудыг дэд бүтцээр холбох том төсөл. Ази Европыг холбох ихээхэн ач холбогдолтой. Тэгвэл энэхүү төсөл манай улс яаж

оролцох вэ. Хоёр хөрш улстайгаа ямар хот, тосгодоор хэрхэн яаж холбогдох вэ. Газ, автозам, төмөр зам, агаарын тээврийн харилцаанд хөрш гурван улс хэрхэн оролцох талаарх томоохон баримт бичгүүдийг хэлэлцэж байгаа. Энэ хүрээнд дэлхий дахинаараа сонирхдог уул ус, ан амьтан, үзэсгэлэнт байгаль, өв уламжлал, соёлын аялалын маршрут гурван улсын уулзалтын хүрээнд хөндөгдөнө. Тиймээс энэ том төслийн хүрээнд "Цайны зам" –ын гурав дахь уулзалт ирэх жил манай улсад зохион байгуулагдах юм. Энэхүү санаачлагад идэвхтэй оролцоноор манай улсын дэд бүтэц, аялал жуулчлалын салбар

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

1. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар "Чингэлтэй дүүргийн 2 дугаар амбулаторийн хуучин барилгыг буулгаж, шинээр барих оношилгоо, эмчилгээний төвийн барилгын зураг төсөл боловсруулах" НХААГ-17/0171 дугаартай ажлыг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газраас 2017 онд хийгдэх болно.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараах мэдээллийг ирүүлнэ:

- Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- Тусгай зөвшөөрлийн хуулбар

-Барилга хот байгуулалтын яамны:

-1.2.1 1-10 хүртэл давхар барилга байгууламжийн барилга архитектур, орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилт, барилга бүтээцийн зураг төсөл, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ)

-1.2.4 Дотор усан хангамж, ариутгах татуурга, халаалт, салхивч агаар сэлгэлт, хөргөлтийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл

-1.2.5 Дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл (10 кВ хүртэл) Дотор радио холбоо, галын болон бусад дохиоллын систем, дохиолол, мэдээллийн байгууламжийн зураг төсөл, хамгаалалтын систем, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, компьютер хангамжийн дотоод сүлжээ, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл /КИП/, автоматикийн зураг төсөл тусгай зөвшөөрлийн хуулбар

- Тус ажлыг хийж гүйцэтгэх инженер техникийн ажилтны дэлгэрэнгүй мэдээлэл, CV
- Сүүлийн 3 жилд /2014, 2015, 2016 он/ хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын жагсаалт, дэлгэрэнгүй мэдээлэл

Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ.Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 Mb, нэг файлын хэмжээ 15 Mb байна.

4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 08:00 цагаас 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 17:00 цаг хүртэл авч болох бөгөөд Цахим Худалдан авах систем (www.tender.gov.mn)-ээр 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 10:00 цагийн дотор ирүүлнэ үү.

Чингэлтэй дүүрэг, Багаторуу-15, Самбуугийн гудамж, Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр, 10 давхар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, 1011 тоот. Утас: 75757810

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: "Улаанбаатар хотын Нийтийн номын сан болон Налайх, Багануур, Багахангай дүүрэг, Сонгинохайрхан дүүргийн Жаргалант тосгоны Соёлын ордны дэргэдэх номын сангуудыг цахим системд холбох ажлын хүрээнд худалдан авах компьютер, техник хэрэгсэл, бусад дагалдах төхөөрөмжүүд"

Тендер шалгаруулалтын дугаар: НХААГ-17/0046

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар эрх бүхий тендер оролцогчдоос "Улаанбаатар хотын Нийтийн номын сан болон Налайх, Багануур, Багахангай дүүрэг, Сонгинохайрхан дүүргийн Жаргалант тосгоны Соёлын ордны дэргэдэх номын сангуудыг цахим системд холбох ажлын хүрээнд худалдан авах компьютер, техник хэрэгсэл, бусад дагалдах төхөөрөмжүүд" нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээс зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендер оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50 000 (тавин мянга) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил /2015, 2016 он/-ийн борлуулалтын орлогын дундаж нь тендер санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.**
1. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 онуудын аль нэг жилд багц тус бүрт тендер санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй ижил төстэй ажил хийсэн байна.**
2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Тендер санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх.**
3. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 он.**
4. Тендерийн баталгааны үнийн дүн: **211,000 /хоёр зуун арван нэгэн мянган/ төгрөг дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.**

Цахим тендер оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулна.

Тендерийг 2017 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 09 цаг 00 минутаас өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 09 цагт 30 минутад Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын тендерийн нээлтийн өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй. Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15, Самбуугийн гудамж, Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр, 10 дугаар давхар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Утас: 75757810 Цахим хаяг: www.tender.gov.mn, www.ub-procurement.mn

УЛС ТӨР

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ-2017

ХАН-УУЛЧУУД МОНГОЛ УЛСЫН ТАВ ДАХЬ ЕРӨНХИЙЛӨГЧ “АЖИЛЧНЫ РАЙОН”-ООС ТӨРНӨ ХЭМЭЭЛЭЭ



Н.ПУНЦАГБОЛД

Эх орныхоо хөгжил дэвшилд хөлс хүч, хөдөлмөр бүтээлээрээ хөрөнгө оруулж, үйлдвэржилт, бүтээн байгуулалтын өрнүүн их ажилд гар, бие оролцож явсан олон арван Хөдөлмөрийн баатрууд “ажилчны район” гэгдэж асан Хан-Уул дүүргээс төржгарсан түүхтэй. Улаанбаатар хэмээх их айлын нүүр царай, өнгө төрх, үүд хаалга болсон тус дүүрэг өдгөө өдрөөс өдөрт өргөжин тэлж, үйлдвэржилт, бүтээн байгуулалтын төв цэг гэгдэж байна. Энэ л дүүргээ, Хан Богд уулаа түшин, хатан Туул голоо эмжин жаргасан Хан-Уул дүүргийн иргэд, сонгогчид Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгч “ажилчны район”-оос төрнө хэмээн дуу нэгтэй хэлж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшигч Х.Баттулга нийслэлийн иргэд, сонгогчидтой хийх уулзалтынхаа хүрээнд төрж өссөн Хан-Уул дүүргээ ажиллаж, мөрийн хөтөлбөрөө танилцуулаа. Өчигдөр “Буянт-Ухаа” спорт цогцолборт болсон уг уулзалтад нэр дэвшигч Х.Баттулгын

эж Ц.Должинсүрэн, УИХ-ын гишүүн, Ардчилсан намын дарга С.Эрдэнэ, УИХ-ын гишүүн асан Ц.Оюунгэрэл, Нийслэлийн Ардчилсан намын дарга Д.Баттулга, Хан-Уул дүүргийн Ардчилсан намын хэрэг эрхлэх газрын дарга н.Дамдин, Соёлын гавьяат зүтгэлтэн, яруу найрагч Ц.Хулан зэрэг хүндэт зочдоос гадна иргэд, сонгогчид оролцлоо. Хан-Уулчууд дүүргээс нь төрөн гарч, төр түшиллэж явсан хүүгээ 100 хувийн саналаар гаргана гэдгээ хэлж байв. Ажил хөдөлмөрийн амт шимтийг мэддэг Хан-Уулчууд үйлдвэржсэн, хүчирхэг Монголыг цогцлоохын төлөө өдий хүртэл сайн муугаар хэлэгдсээр ирсэн ч ноён нуруутай байж өдий хүрсэн Х.Баттулгыгаар гээд улс орны тулганы галыг өрждөг байдаг эдийн засгийн голлох салбаруудыг нэгэн цагт удирдан чиглүүлдэг явсан нэр дэвшигч Х.Баттулга төрж өссөн дүүргээс өрнүүн их ажил өрнүүлснээс дурдвал “Шинэ Яармаг” цогцолбор хороолол,

Богд уулын арын зам, “Буянт-Ухаа” I, II хорооллыг онцолж болно. Уулзалтын үеэр нэр дэвшигч Х.Баттулга “Тэртээ 1970 оны эхэн үед гурав, дөрөвдүгээр ангийн Баттулга Яармагийн дэнжээс хот руу саравчлан зогсохдоо олон сайхан зүйл мөрөөддөг байв. Гэр маань хотоос 10-аад км зайтай болохоор тухайн үед “Хот орж үзэхсэн” гэх гэнэн мөрөөдөлд хөтлөгдөж явжээ. Улмаар алсаас ширтэж, мөрөөсч зогссон хотдоо ирж, хөгжил цэцэглэлтийг нь хараад гайхан бахдаж байв. Үүнээс хойш дунд сургуулиа төгсөөд Дүрслэх урлагийн дунд сургуульд элсч, хажуугаар нь хүүхдийн хувцас оёж эхэллээ. Зургийн сургуулийн оюутнууд гэрийн даалгавраа томоо гэгч ватум цаас нь дээр хийж авч явдаг байсан болохоор олон хүн чихэлдсэн автобусаар зорчих хэцүү байж эв. Тиймдээ ч таксигаар зорчдог оюутан болохсон гэж мөрөөддөг болов. Улмаар хүүхдийн хувцас оёхын зэрэгцээ зураг зурж, “Баянгол” зочид буудлын үүдээр явж жуулчдад зарах боллоо. Ингэснээр мөрөөдөж байсан таксигаа ч хөлөглөдөг нэлээд додигор оюутан боллоо. Ийнхүү

хот орон газар үзэж, сургууль соёлд элсч, бас ч гэж гадны жуулчдад гар урлалын бүтээлээ зарж эхэлсэн би гадаад улс орон руу явж үзэхсэн гэх дараагийн мөрөөдлөөрөө жигүүрлэсэн юм. Тухайн үед сайн тамирчин, сайд дарга нар л гадагшаа дотогшоо явдаг байв. Мэдээж хорь ч хүрээгүй хүүхэд юу юугүй сайд дарга болохгүй нь ойлгомжтой. Тиймдээ ч тамирчин болохоор шийдсэн хэрэг. Спортын ертөнцөд оройтож хөл тавьсан ч санасандаа хүрч, дэлхийнаваргын дэвжээнд төрийн далбаагаа ч мандуулсан, гадаад улс орон руугаа явж үзсэн. Үүний дараа орон сууцанд амьдрахсан гэх хүсэлдээ хөтлөгдсөөр Энэбиш дарга дээр ортол “Дахиад нэг алтан медаль авчих, тэгвэл орон сууцтай болгох өгье” гэж байна. Нэг удаа чадсан юм чинь яагаад хоёр дахиа чадахгүй гэж бодсоор Дэлхийн домын тэмцээнээс алтан медаль авсан. Энэ мэт Яармагийн дэнжээс хот руу саравчилж зогссон Баттулгыг юу энэ хүртэл явуулсан бэ гэвэл ердөө л хүсэл мөрөөдөл хийгээд түүнийхээ төлөө тэмцдэг уйгагүй, хөдөлмөрч зан чанар юм шүү” гэв.

Азай буурал ээж, ачит багш, анд нөхдийн захиас

Нэр дэвшигч Х.Баттулга төрж өссөн дүүргээ ажиллаж, мөрийн хөтөлбөрөө танилцуулсан эл уулзалт сонин содон зүйлээр дүүрэн болж өнгөрөв. Тухайлбал, нэр дэвшигчийн ээж Ц.Должинсүрэн гуай 1970-аад онд нүүж ирсэн хуучин буйран дээрээ буюу Яармагийн гэр хороололдоо одоо ч аж төрөн суугаа бөгөөд хүүгийнхээ уулзалтад биечлэн ирж, сонгуульд ажилд нь амжилт хүсч, ерөөлийн үгээ хайрласан юм. Түүнчлэн, долоон настай Х.Баттулгыг Хан-Уул дүүргийн 34 дүгээр сургуульд элсч ороход анх үсэг нүдлүүлсэн ангийн багш Алтанцэцэг нь ч эл уулзалтад хүрэлцэн ирж, шавьдаа хандаж үг хэлсэн. Тэрбээр “Одоо ч тодхон санаж байна. Багш хэмээх эрхэм алдрыг хүртэж, анхны анги дааж авсан нь манай Баттулгын анги байсан юм. Баттулга маань багын л юманд хичээнгүй, уйгагүй, хөдөлмөрч хүүхэд байсан. Ээжийнхээ оёдлын машиныг авчраад

ангийнхандаа урлагийн үзлэг, элдэв тэмцээн уралдаанд өмсөх хувцасыг нь оёод өгчихдөг тийм л хүүхэд байв. Хол явж, их үйл бүтээх хүн андашгүй байдаг юм билээ. Баттулгын нүднээс үзүүр хязгаар нь үл харагдах мөрөөдөл гэрэлтдэг байв. Одоо ингээд харж суухад шавь минь санасан мөрөөдсөн бүхэндээ хүрчээ. Гэхдээ нэг л мөрөөдөл үлдсэн хэмээн сая өөрөө хэлж байна. Энэ мөрөөдөл нь зөвхөн Баттулгын бус миний, чиний, монголчууд бидний мөрөөдөл гэдэгт эргэлзэхгүй итгэж байна” гэсэн юм. Үүний дараа Х.Баттулгатай 20 гаруй жил нөхөрлөж буй найз нь болох Гавьяат жүжигчин Хүрэлхүү үг хэллээ. Тэрбээр “Сонгууль гэж хэн нь хэн болохыг харуулдаг, танилдаг нэг талаас сайхан зүйл юм. Өдий болтол миний найзыг элдэв гүжир гүтгэлгээр өдөр шонгогүй булж байна. Ийм их дарамт, стрессийг Тулгаа яаж тэсч давж гардагийг гайхдаг. Би нэг л зүйлийг баттай, 100 хувь итгэл дүүрэн хэлж чадна. Баттулга хэзээд өөрөөрөө байж чаддаг, жинхэнэ эр хүн юм шүү. Анх төрөх эмнэлэгт танилцаж байсан тэр залуу 20 гаруй жилийн дараа ч тэр л янзаараа, Баттулга хэвээрээ байгаад нь баярладаг. Тиймдээ ч эл сайхан нөхөрлөлөө эрхэмлэж, нандингаж явдаг юм. Мөнгөтэй хүмүүс нэр нөлөөтэй урлаг соёлынхныг бараа таваар мэт худалдан авч, муу муухайдаа ашиглаж байгааг бид бүхэн харлаа. Надад ч гэсэн тийм санал цөөнгүй ирсэн. Гэхдээ би нөхөрлөлдөө үнэнч үлдэж Тулгынхаа талд зогсч үлдсэн. Энд нэг зүйлийг нэмж хэлэхэд Тулга бид хоёрын дунд ямар ч мөнгө төгрөг, гэрээ контракт байхгүй. Харин найз нөхрөө гэсэн халуун сэтгэл л бий” гэсэн юм. Ийнхүү Яармагийн дэнжээс их хот руу саравчлан зогссон жайлхан Баттулга биелээгүй үлдсэн ганц мөрөөдлөө тээсээр төрж өссөн Хан-Уул дүүргийнхээ дэг эрдтэй уулзан учирч, төрд айлч үгийг нь сонссон юм. Яагаад Яармагийн дэнжээс Ерөнхийлөгч төрж болохгүй гэж...

Дарханчууд М.Энхболдыг ДЭМЖИНЭ ГЭВ

Монгол Улсын Ерөнхийлөгчид Монгол Ардын намаас нэр дэвшигч М.Энхболд Бурхангийн хөндийд их хот байгуулж, үйлдвэр, завод бүтээн босгогчидтой уулзлаа. Орос ах нарын байгуулж өгсөн найрамдлын хот Дархан Монгол орны нэгэн өвөрмөц нүүр царай, их үйлдвэрийн хот билээ. Дархан-Уул аймаг Монгол Улсын томоохон аж үйлдвэрийн төв төдийгүй дэд бүтэц сайн хөгжсөн, Улаанбаатар-Алтанбулагийн чиглэлийн олон улсын автозам, Улаанбаатар-Сүхбаатарын төмөр замын зангилаан дээр оршдог. Тиймээс ч дарханчууд М.Энхболдын “Монгол төр-Монгол гэр” мөрийн хөтөлбөрт нухацтай хандаж, аж үйлдвэрийн парккийг цаасан дээр биш газар дээр нь байгуулахыг хүсч, шинэ төмөр зам барих Засгийн газрын үйл ажиллагааг бодитойгоор дэмжин ажил хэрэг болгохын төлөө хаа хаанаасаа хүчээ нэгтгэх хэрэгтэй хэмээн Ерөнхийлөгч болоод хийх ажлынх нь захиасыг өгч байлаа. Дархан-Уул аймгийн нийт нутгийн 70 гаруй хувийг хөдөө аж ахуйн эдэлбэр газар эзэлдэг учир атрын аяны хүрсэн төвшинг ахиулах, орон нутгийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бүхий л үйл ажиллагааг дэмжиж ажиллахаар мөрийн хөтөлбөртөө тусгасан нь тэдний хувьд боломж гэнэ. Мөн 91 мянга гаруй хүн амынх нь 60 гаруй хувийг 35 хүртэлх насныхан эзэлдэг тул залуучуудаа дэмжих



бодлого хэрэгжүүлэхээр тусгасан нь ч тэдэнд таалагджээ. Дарханчуудад М.Энхболдын Мөрийн хөтөлбөр нь амьдралд нийцсэн, хэрэгжүүлэх эзэн нь Монгол төрийн өндөр босгыг даваад цаана нь гарах чадалтай болохоор бид дэмжинэ. М.Энхболдод төрийн жолоог атгуулахад бид санаа зовох юмгүй амьдарч болно гэж хийлаа. МАН-ын нэр дэвшигчтэй хийсэн дарханчуудын уулзалт сайхан мэдээтэй эхэлсэн нь Улаанбаатар-Дархан чиглэлийн автозамыг олон улсын стандартад нийцүүлж, дөрвөн эгнээтэй барьж байгуулах ажлыг эхлүүлсэн өдөртэй давхацсан нь байлаа. Олон жил жолооч зорчигчдыг зовоосон энэ замын шинэчлэгдэхийг дарханчууд хүсэн хүлээж байжээ. Монгол Ардын намын төр засгийн эрхэнд гарсан даруйдаа тэдний хүслийг биелүүлэх ажилдаа ийнхүү хамттай шамлан орж буйд дарханчууд халуун алга ташилтаар талархал илэрхийллээ. Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгчид нэр дэвшигч

М.Энхболдын Дарханд болсон уулзалтад гэнэтийн зочид очсон нь иргэний хөдөлгөөнийхөн байлаа. Таны уулзалтад оролцох гээд гүйцэхгүй байна. Өнөөдөр харин Дарханд л угтаж амжлаа хэмээн өгүүлсээр Үндэсний хас, Эрс шинэчлэл, Жудагт Монгол зэрэг таван хөдөлгөөн болон МАХН-ын гишүүн, дэмжигчдийн холбооны төлөөлөл үг хэлсэн юм. Иргэний хөдөлгөөнийхөн яагаад М.Энхболдыг дэмжих болсон талаар Шударга иргэдийн фронтын тэргүүн Г.Арслан, “Ухаантай хүн өрсөлдөгчөө өөртөө татдаг, урагшгүй хүн анд нөхдөө ч түлхдэг” гэдэг. Хэдийгээр бид МАН-ын зарим үйл ажиллагаанд шүүмжлэлтэй ханддаг ч М.Энхболдын дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр бидний зөв гэсэн үйл хэрэгтэй маань нийцэж байгаа болохоор түүнийг дэмжиж, хамтран зүтгэхийг хүссэн юм. М.Энхболд биднийг нааш ир гэж дуудаагүй, тэр бас биднийг яв гэж хэлэхгүй. Хамтраад дэмжээд л явах хүн гэдгийг улс төрд оролцож, энэ

үйл хэргийн төлөө явдаг хүний хувьд би мэднэ. Тиймээс энд ирсэн Иргэний хөдөлгөөнийхөн бид ухаантай хүнийг дэмжихээр шийдсэн юм гээд нөгөө талд яваа нэр дэвшигчийн талаар ч та бүхэнд үнэнийг хэлэхийг хүсч байна. Нэр дэвшигчээ дэмжин хамт яваа УИХ-ын дэд дарга Ц.Нямдорж, Монгол Улсын хамгийн том дарга төрийн гурван өндөрлөг биш, иргэд сонгогчид та нар шүү. Ямар шийдвэр гаргахыг та нар мэднэ, сонголтоо зөв хийгээрэй хэмээн захилаа. Монгол Ардын намынхан эдийн засгийг сэргээдэг бол АН-ынхан ширгээдэг сургамжийг санаж, найрамдан эвлэлдэхийг эрхэм болгосон дарханчууд нэр дэвшигч Миеэгомбын Энхболдыг дэмжихээ илэрхийллээ. Мөн Засгийн газрын мөрийн хөтөлбөрөө дэмжиж, УИХ-тайгаа хамтарч ажиллах, ярьдаг биш хийдэг, талцуудад биш эвлэрүүлдэг, дүр эсгэдэггүй Ерөнхийлөгч Миеэгомбын Энхболд л байж чадна гэж байв.

Дорноговьчууд С.Ганбаатарыг сонгож, төрийн хулгайг зогсооно



МАХН-аас Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч С.Ганбаатар Дорноговь аймгийн иргэд сонгогчидтой уулзлаа. Сайншанд хотын төвд цугласан иргэд “МАХН уухай уухай” гэсээр нэр дэвшигчийг угтлаа. Тус аймгийнхан Монгол Улсын дараагийн Ерөнхийлөгч хэн байх вэ гэдгийг аль хэдийн сонгосон гэдгээ илэрхийлжээ. Нэр дэвшигч С.Ганбаатар тус аймгийн зах худалдааны төвүүдээр явж хөдөлмөр эрхлэгчидтэй уулзаж мөрийн хөтөлбөр болон хариуцлагын гэрээгээ танилцуулав. Тэрбээр “Оюутолгойгоо ард иргэддээ ашигтай болгох гарц бидэнд бий. Цалин тэтгэвэр нэмэх, залуучуудаа ажлын байртай болгох өөр гарц бий. Монгол хулгайгүй, шударга болсон цагт босно. Үүнийг засах гэж би олон жил та бүхэнтэйгээ хамтдаа тэмцсэн. Харин одоо бид хамтдаа дээрээс нь шүүрдэх цаг болсон” гэлээ. Иргэд оффшор данс эзэмшээгүй, авилга албан тушаалын хэрэгт холбогдоогүй нэр цэвэр С.Ганбаатарыг дэмжинэ гэдгээ илэрхийлж байв. Мөн МАХН-аас шинэ үндсэн хуулийн төсөл боловсруулж 21 аймгийн ард иргэдэд танилцуулсан. Энэ хуулийн төсөлд Монгол хүн төрийн хамгаалалтад байх, байгалийн баялагийг тэгш хүртээх зэрэг өнөөдөр нэн шаардлагатай олон заалтыг тусгасан билээ. Дорноговь аймгийн иргэд нэр дэвшигч С.Ганбаатарын төлөвлөгөөнд итгэж байна. Мөн Дорноговьчууд төдийгүй Монголын ард түмэн С.Ганбаатарыг сонгох ёстой гэдгийг уриаллаа.

ЦАГ ҮЕ

МЭДЭЭЛЭЛ

НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ



“ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ” СЭДЭВТ ОНОЛ ПРАКТИКИЙН ЗӨВЛӨГӨӨН БОЛЛОО

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба үүсэн байгуулагдсаны түүхт 20 жилийн ойг тохиолдуулан өчигдөр “ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ” сэдэвт онол практикийн зөвлөгөөнийг амжилттай зохион байгууллаа. Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үр дүнтэй, процессын алдаагүй, хуулийн хүрээнд шуурхай гүйцэтгэх, учирч буй эрсдлийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох, цаашдын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх, практик тогтоон, зөвлөмж, шийдвэр гаргах зорилготой зохион байгуулагдсан тус зөвлөгөөнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа анги, алба, хэсгийн албан хаагчид, Хууль сахиулахын их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн багш, албан хаагч, сонсогчид оролцов.

Энэхүү зөвлөгөөнд “Эд хөрөнгийн мэдүүлэг авах шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онцлог” сэдвээр Баянгол дүүргийн шийдвэр гүйцэтгэгч Ю.Оюунаа, “Торгох ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт” сэдвээр Хууль сахиулахын их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн 531 дүгээр дамжаа, дэд түрүүч С.Пүрэвбаатар, “Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа” сэдвээр Хан-Уул дүүргийн шийдвэр гүйцэтгэгч Ш.Бямбадорж, “Барьцаа хөрөнгийг захиран зарцуулах” сэдвээр Нийслэлийн давж заалдах шатны иргэний танхимын шүүхийн шүүгч Ц.Ичинхорлоо, “Үл хөдлөх эд хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагаанд тулгамдаж буй зарим асуудал” сэдвээр Хууль сахиулахын их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн 522 дугаар дамжааны сонсогч О.Батхуяг, “Албадан дуудлага худалдаанд орж буй үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ” сэдвээр Баянзүрх дүүргийн шийдвэр гүйцэтгэгч Э.Ундармаа “Албадан ажил хийлгэх ялын хэрэгжилт, шинэчилсэн хуулийн өөрчлөлт, харьцуулалт” сэдвээр Хорихоос өөр төрийн ял эдлүүлэх тасгийн шийдвэр гүйцэтгэгч, дэслэгч Б.Болортулга, “Эд хөрөнгө хураах ялын шинэчлэл ба нуугдал эд хөрөнгө илрүүлэх ажиллагааны өөрчлөлт” сэдвээр Хууль сахиулахын их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн 521 дүгээр дамжааны сонсогч, түрүүч С.Бамба-Эрдэнэ нар тоо баримт, статистик үзүүлэлтэд тулгуурласан шинэ санаа дэвшүүлсэн онол практикийн ач холбогдолтой илтгэлүүдийг тус тус хэлэлцүүлсэн юм.

Зөвлөгөөнөөр хэлэлцүүлсэн илтгэлүүдийг эмхэтгэн нийтлүүлж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа төв орон нутаг дахь шийдвэр гүйцэтгэлийн алба нэгжүүдийн албан хэрэгчдэнд хүргүүлэн, цаашид Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны нэрэмжит илтгэлийн уралдааныг жил бүр зохион байгуулахаар шийдвэрлэжээ.

Төгсгөл. Түрүүч нь I нүүрт

Тодруулбал, алслагдсан гурван дүүрэг болон 21 аймгийн төвд нэгэн зэрэг зохион байгуулагдсан. Өдөрлөгт Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагуудаас ХНХЯ-ны харьяа Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар өргөн бүрэлдэхүүнээр ажиллаж, иргэдэд хэрэгтэй дэлгэрэнгүй мэдээллийг өгч байлаа. Мөн харьяа байгууллагууд, судалгааны төвүүдээс гадна ажил олгогч аж ахуйн нэгжүүд, ТББ-ууд өдөрлөгт оролцов. Өдөрлөгийн үеэр ХНХЯ-наас хамгийн том “Хөдөлмөрийн бирж” ажиллуулж иргэдийг ажлын байраар хангах томоохон зорилгыг тавьсан билээ.

Уг арга хэмжээнд нийтдээ 60 орчим аж ахуйн нэгж нэгдэж, иргэдийг нээлтэй ажлын байрандаа бүртгэж, сонгож авах үйл ажиллагаа явуулсан юм. Мөн эрүүл мэнд, нийгмийн даатгал, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн бүлгүүд, гэр бүл-хүн амын хөгжил, нийгмийн халамжийн зэрэг олон талт бодлого, хууль эрх зүйн танилцуулга, арга хэмжээ, үйлчилгээг нэг дороос иргэдэд түргэн шуурхай хүргэж ажиллав. Иргэд ажлын байранд бүртгүүлэх үйл ажиллагаанд нэлээд идэвхтэй оролцож байсан. Мөн Эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалтай холбоотой асуудлууд болох элэгний В, С вирусийн эмийн үнийн хөнгөлөлт болон бүсэд тушаал шийдвэрүүдийн талаарх мэдээллийг илүүтэй сонирхож байлаа.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

“Хөдөлмөрийн бирж” зорилгоо биелүүлэв

Нээлттэй хаалганы өдөрлөгт улсын хэмжээнд нийт 50 мянга орчим иргэд оролцсон байна. Үүнээс 15 мянган иргэн “Хөдөлмөрийн бирж”-ээр үйлчлүүлж ажлын байрны захиалгад бүртгүүлжээ. Тоог нарийвчилж задалбал ажилд бүртгүүлсэн иргэдийн 11.000 нь нийслэл хотод, үлдсэн 4000 иргэн нь алслагдсан гурван дүүрэг, аймгуудад бүртгүүлжээ. Тэгвэл эдгээр иргэдээс 2000 орчим иргэн ажил олгогчдоос тавьсан шаардлагыг хангаж ажилд орох эрхээ авсан байна. Мөн Хөдөлмөр, халамжийн чиглэлээр хоёр өдрийн хугацаанд нийт 15720 иргэнд мэдээлэл хүргэж ажилласан байна.



ЭМНД-ын чиглэлээр 9770 иргэнд мэдээлэл өгч, шаардлагатай үйлчилгээний түргэн шуурхай үзүүлээ

Нээлттэй хаалганы өдөрлөгт Эрүүл мэнд нийгмийн даатгалын ерөнхий газар, төвийн зургаан дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн ажилтан албан хаагчид оролцсон юм. Өдөрлөгийн үеэр элэгний С вирусийн эсрэг “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн талаар, цалин, тэтгэврийн зээлийн хүү буурч, шимтгэл тэглэсэн талаар, тэтгэвэрээ шимтгэл, хүүгүйгээр урьдчилан авах боломжтой болсон гэх мэт иргэдийн илүүтэй сонирхож байсан мэдээ мэдээллийг хүргэж үйлчилжээ. Мөн тэтгэврийн хяналтын аян, тэтгэвэр авагч банкаа сонгох болсон зэрэг сүүлийн үед хэрэгжиж буй бодлого, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг иргэдэд өгсөн. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын чиглэлээр нийт 9770 иргэнд мэдээ мэдээлэл өгч, шаардлагатай үйлчилгээний түргэн шуурхай үзүүлжээ. Үүнээс Улаанбаатар хотод 3188 иргэн, орон нутагт 6582 иргэн хамрагдсан байна.

Эрэлттэй мэргэжлүүдийг сонгож 350 залуу МСҮТ-д шинээр элсээ

“Нээлттэй хаалганы өдөрлөг”-т Мэргэжлийн боловсрол, сургалтын төвийн 57 байгууллага оролцсон бөгөөд хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн танилцуулга, багш сурагчдын бүтээл болох үндэсний хувцас, сүлжмэл хувцас, модон эдлэл, гагнуурын бүтээлүүд, ном сурах бичиг, бүтээлийн сурталчилгаа, барилгын засал чимэглэлчин, мэргэжлийн мозайк арт утсан чимэглэл, байшингийн скиз загвар зэргийг олон нийтэд танилцуулж, нийт 11000 гаруй иргэдэд мэдээлэл хүргэж үйлчилжээ. Мөн 350 гаруй элсэгч МСҮТ-үүдэд бүртгүүлсэн байна. Үүнээс Улаанбаатар хотод 112, аймгууд болон алслагдсан гурван дүүрэгт 248 хүүхэд, залуус бүртгүүлжээ. Мөн багш, суралцагчдын хийсэн гурилан

...Эрүүл мэнд, нийгмийн даатгалын чиглэлээр нийт 9770 иргэнд мэдээ мэдээлэл өгч, шаардлагатай үйлчилгээний түргэн шуурхай үзүүлжээ. Үүнээс Улаанбаатар хотод 3188 иргэн, орон нутагт 6582 иргэн хамрагдсан байна...

бүтээгдэхүүн, кекс, нарийн боов, жимсний ундаа, боловсруулсан цагаан идээний амталгааг зохион байгуулж иргэдэд танилцууллаа.

“Нэн түрүүнд ХАБ” уриатай ажилтан албан хаагчид шинэ технологиор хийгдсэн ажлын хувцсыг танилцуулаа

Үйлдвэрийн орчин, нөхцөлийг сайжруулах, ажилтныг ажлын байран дахь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл болон бусад эрсдэлт хүчин зүйлийн нөлөөлөөс хамгаалах, түүнээс урьдчилан сэргийлэх, ХАБЭА-н үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай дөвшилтэт технологийг өдөрлөгийн үеэр нийтийн хүртээл болгож ажилласан юм. Энэхүү зорилгын хүрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, зөвлөгөөг олон нийтэд хүртээмжтэй хүргэж чадлаа. Өдөрлөгийн үеэр

ХАБЭМТөөр нийт 1019 хүн үйлчлүүлжээ. Үүнээс ХАБЭА-н стандарт, дүрэм журам, сургалтын эрх авах, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ зэрэг асуудлаар 799 хүн зөвлөгөө, мэдээлэл авсан байна. Харин Мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд нийт 220 иргэнд эрүүл мэндийн анхан шатны зөвлөгөө өгч, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрууллаа. Түүнчлэн “Нано загвар” компанийнхан нано технологийг ашиглан хийсэн ажлын хувцас, хэргэслүүдээ танилцуулсан юм. Эдгээр хувцас хэргэсэл нь ус нэвтэрдэггүй бөгөөд гагнуурын очинд түлэгддэггүй гэдгээрээ онцлог, давуу талтай юм.

“Хуулиа мэдэж, эрхээ эдэлж, үүргээ биелүүлцгээ”

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар харьяа байгууллагуудын хамт оролцож, олон нийтэд үйл ажиллагаагаа сурталчилсан юм. Тухайлбал, Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар, Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар, Олон улсын хүүхдийн “Найрамдал” цогцолбор, Өнөр бүл хүүхдийн төв, Хүүхдийн тусламжийн утасны 108 үйлчилгээний төв, Зуслангуудын холбоо, Сурагчдын холбоо, Скаутын холбоо зэрэг байгууллагууд иргэдэд үйлчилж өөр өөрсдийн чиглэлээр мэдээлэл өгч ажиллалаа. Түүнчлэн иргэдэд салбарын хууль тогтоомжуудыг сурталчилж, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай, Хүүхдийн эрх, Хүүхэд хамгааллын тухай хуулиудаар тус тус сургалт хийсэн юм. Мөн энэг эхчүүдэд зориулан хүүхдэд хэрхэн эерэг аргаар хүмүүжүүлэх талаар арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг зохион байгууллаа.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдөр
Тендер шалгаруулалтын нэр: Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй 361 дүгээр гарам орчим цагдаагийн хэсгийн байр барих /СХД, 21 дүгээр хороо/ зураг төсөв, барилга угсралтын ажил
Тендер шалгаруулалтын дугаар: НХААГ-17/0192

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос “Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй 361 дүгээр гарам орчим цагдаагийн хэсгийн байр барих /СХД, 21 дүгээр хороо/ зураг төсөв, барилга угсралтын ажил”-ыг түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 /тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түнхийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн туршид хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. **Үүнд:**

Борлуулалтын орлогын нийт мөнгөн дүнгийн сүүлийн 2 жилийн /2015, 2016 он/ дундаж нь:
 Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх.

Сүүлийн 2 жилийн /2015, 2016 он/ аль нэг жилд дор хаяж 1 удаа санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй тусгай зөвшөөрлийн хүрээнд хийгдсэн ажлын ерөнхий гүйцэтгэгчээр ажилласан байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:
 Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: Тийм
 Зураг төсөл боловсруулах байгууллага нь дараах тусгай зөвшөөрөлтэй байна.

Барилга хот байгуулалтын яамны:
 1.2.1. 1-10 хүртэл давхар барилга байгууламжийн барилга архитектур, орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилт, барилга бүтээцийн зураг төсөл, барилгын зохион байгуулалтын зураг түсэл, түүнтэй дүйцэхүйц эсвэл түүнээс дээш заалт
 Ажил гүйцэтгэх байгууллага нь дараах тусгай зөвшөөрөлтэй байна.
Барилга хот байгуулалтын яамны:
 -2.1.2. Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил (1-5 давхар хүртэлх) болон түүнээс дээш заалт
 -2.2.1. Барилгын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт
 -2.2.2. Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт
 Тендерийн хамт 1,519,000 (нэг сая таван зуун арван есөн мянга) төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.
 Цахим систем тендерийн баталгаа гаргагч арилжааны банкны мэдээллийн сангаас тендерт оролцогчийн тендерийн баталгааны талаарх мэдээллийг шалгана.
 Тендерийг 2017 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 09 цаг 00 минутаас өмнө Цахим худалдан авах систем (www.tender.gov.mn)-ээр ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байшуулан тендерийг 2017 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 09 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх: Эрхгүй Дотоодны давуу эрх тооцох эсэх: Тооцно
Сонирхсон этгээд тендерийн барилт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15, Самбуугийн гудамж, Нийслэлийн засаг захиргааны 4 дүгээр байр, 10 дугаар давхар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар
 Утас: 75757810

Цахим хаяг: www.tender.gov.mn, www.ub-procurement.mn

СПОРТ

FOOTBALL NEWS

Оросын шигшээ ХОЛБООДЫН ЦОМООС МУЛТРАХ УУ

Н.ПУНЦАГБОЛД

2018 оны хөлбөмбөгийн ДАШТ-ийг эх нутагтаа зохион байгуулах гэж буй ОХУ-д Холбоодын цомын тэмцээн эхэлсэн билээ. Энэхүү тэмцээнд зохион явуулагч ОХУ, Дэлхийн аварга Герман, Азийн аварга Австрали, Америкийн аварга Чили, Алтан цомын аварга



Мексик, Европын аварга Португал, Африкийн аварга Камерун, Далайн орнуудын аварга Шинэ Зеланд зэрэг найман улсын шигшээ баг оролцож байгаа юм. Тэмцээний эхний тойргийн тоглолтууд болсон. Тэгвэл өнгөрсөн хэсгийн хоёрдугаар тойргийн тоглолтууд боллоо. Эхний тойрогт Мексиктэй тэнцсэн Европын аварга Португалын шигшээ баг Оростой тулж, 0:1-ээр буулгаж авлаа. Ингэснээр дөрвөн оноотой

болж, хэсгээс гарах боломжоо үлэмж хэмжээгээр нэмсэн юм. Тоглолтын хувь заяаг шийдсэн цорын ганц гоолыг Роналдо найм дахь минутад оруулсан юм. Тэгвэл нөгөө талд Мексикийн шигшээ баг Шинэ Зеландтай тулж, 2:1-ээр буулгаж авлаа. Ингэснээр дөрвөн оноотой хэдий ч гоолын зөрүүгээр А хэсгийг тэргүүлж байна. Тоглолтын 42 дахь минутад Шинэ Зеландын шигшээгээс Вуд гоолдож, тооны харьцааг нээсэн. Гэвч 54 дэх минутад Хименес

тэнцүүлж, 72 дахь минутад Перальта гүйцээжээ. Шинэ Зеландын хувьд энэ тоглолтод хожигдсоноор хэсгээс гарах боломжгүй боллоо. Харин Орос хожигдсоноор гурван оноотой үлдэж, гуравдугаар байрт бичигдэж байгаа юм. Маргааш Оросын шигшээ Мексиктэй тулах учиртай. Энэ тоглолтод заавал хожиж байж хагас шигшээд шалгарах учиртай юм. Хэрвээ оноо алдвал Оросын шигшээ Холбоодын цомоос мултрах аюултай болж ирээд байна.

Роналдо "ПСЖ" рүү явахыг хүсэв үү

Испанийн алдарт "Реал Мадрид" клубын хагас хамгаалагч Криштиано Роналдо "ПСЖ" клуб замналаа үргэлжлүүлж магадгүй талаар мэдээлэл гарч эхэллээ. Холбоодын цомын тэмцээний дараа Португал эр "Реал Мадрид"-ын Ерөнхийлөгч Флорентино Перестэй уулзаж, Францын багийн тавьсан саналын талаар ярилцахаар төлөвлөж буй ажээ. Роналдо "Реал"-ыг орхихыг хүсч байгаа ч Европын багт тоглохыг илүүд үзэж буй. Ер нь бол "ПСЖ" түүний төлөө "Реал"-д 100-150 сая евро төлөхийг санал болгож байгаа бөгөөд өөрт нь жилийн 30 саяан цалин санал болгосон билээ. Энэ өндөр цалин түүнийг Франц руу явахад нөлөөлж байж ч болох юм.

Салах 39 саяар "Ливерпүүл"-д очих нь

Италийн "Рома" клубын хагас хамгаалагч Мохамед Салах Английн "Ливерпүүл"-д ирлээ. "Ливерпүүл" түүний төлөө 39 сая евро төлж байгаа бөгөөд урамшуулалтайгаа нийлээд 45 хүрэх ажээ. Өчигдөр өглөө Салах "Ливерпүүл"-ын эмчийн үзлэгээр орсон юм байна. Тэрбээр шинэ багтайгаа дөрвөн жилийн гэрээ байгуулж байгаа бөгөөд татварын дараах байдлаар 5.5 сая еврогийн цалин авах ажээ.

Месси өнгөрсөн зун "Манчестер Сити"-д очих гэж байжээ

Испанийн алдарт "Барселона" клубын довтлогч Лионель Месси 2016 оны зун "Манчестер Сити" рүү явж, хуучин дасгалжуулагч Хосеп Гвардиолагай хамтарч ажиллахаар төлөвлөж байжээ. El Mundo Deportivo-гийн мэдээлж байгаагаар тэрбээр Аргентины шигшээ багаас зодог тайлж байгаагаа зарласны дараа Каталын багийн удирдлагуудад энэ талаар хэлсэн юм байна. Тийм шийдвэр гаргахад түүний татвараас зайлсхийсэн асуудал ч нэлээд нөлөөлсөн юм байх. "Сити" түүний төлөө 150 сая евро төлөхөд бэлэн байсан аж. Харин Суарез түүнийг ятгасны эцэст багтаа үлджээ. Дашрамд дурьдахад, Месси Аргентины шигшээ багтаа эргээд тоглож байгаа билээ.

Бакайоко "Челси"-д ирвэл Матич явж магадгүй

Английн "Челси" клуб "Монако"-гийн хагас хамгаалагч Тьемуэ Бакайоког 35 сая еврогоор авахад ойрхон байгаа билээ. Хэрвээ Франц хөлбөмбөгч Лондоны багчирвэл Неманья Матич багаа орхих юм байна. "Челси"-гийн дасгалжуулагч Конте ч гэсэн өдгөө 28 настай Сербин эрийн төлөө тавьж буй "Манчестер Юнайтед"-ын саналыг сонсоход бэлэн байгаа аж. "Улаан чөтгөрүүд"-ийн дасгалжуулагч Жозе Моуриньо түүнтэй "Челси"-д хамтарч ажиллаж байсан түүхтэй. Тиймдээ ч багтаа авчрахыг хүсч байгаа юм байна.



МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

Р.Нямдоржийг ажлаа өгөхийг шаарджээ

Монголын үндэсний бөхийн холбооны цэцдийн зөвлөлөөс ээлжит бус "Их ээ" хурлыг өнгөрсөн тавдугаар сард зохион байгуулж, МҮБХ-ны тэргүүнээр "Гачуурт" ХХК-ийн ерөнхий захирал Л.Чинбатыг томилсон ч МҮБХ-ны тэргүүн Р.Нямдорж одоог хүртэл ажлаа хүлээлгэн өгөөгүй байгаа юм. Иймд МҮБХ-ын цэцдийн зөвлөлөөс мэдэгдэл гаргаж ажлаа өгөхийг шаардсан байна. Тэд Р.Нямдоржид энэ сарын 10-ны дотор ажлаа хүлээлгэн өгөхийг шаардсан мэдэгдэл хүргүүлж, энэ сарын 13-нд МҮБХ-ны шинэ удирдлага биечлэн уулзсан боловч шаардлагыг хүлээж аваагүй байна. Тиймээс Р.Нямдоржийг ажлаа нэн даруй хүлээлгэн өгөхийг дахин шаардаж, бөхчүүдийг эв нэгдлээ эрхэмлэж, элдэв хууль бус хурал зөвлөгөөнд оролцохгүй байхыг уриалжээ. Мөн Р.Нямдоржийг ажлаа хүлээлгэн өгөхгүй бол шийдвэртэй арга хэмжээ авна гэдгээ мэдэгдсэн байна.



Хүндийн өргөлтийн тэмцээн эхэллээ

Спортын төв ордны "А" зааланд "Turkish Airlines" компанийн нэрэмжит хүндийн өргөлтийн залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээн өчигдөр эхэллээ. Энэхүү тэмцээнд 15 багийн 170 гаруй тамирчин

эргэтэй, эмэгтэй тус бүр долоон жинд хүчээ сорин өрсөлдөж байна. Тэмцээнд ОУХМ 16, спортын мастер цолтой 14 тамирчин техник, ур чадвар, хүч сорьж байгаа аж. Тэмцээний шилдгүүд өнөөдөр тодорно.

Паурлифтингийн шилдэг тамирчид "Олимпийн алдар" одон хүртэв

Монголын Үндэсний олимпийн хорооны хүндэтгэлийн танхимд өчигдөр Монголын паурлифтингийн холбооны гурван тамирчинд "Олимпийн алдар" одон гардууллаа. Тодруулбал, паурлифтингийн дэлхийн аварга Д.Алтанхуяг, ДАШТ-ий мөнгөн медальт П.Болдбаатар, тивийн аварга Ш.Чанарав нарт МҮОХ-ны Дэд ерөнхийлөгч, Ардын багш, гавьяат тамирчин Ц.Дамдин

МҮОХ-ны "Олимпийн алдар" одонгоор энгэрийг нь мялаажээ. Мөн Монголын паурлифтингийн холбоо энэ сард Монголын үндэсний олимпийн хорооны ээлжит хурлаар МҮОХ-ны гишүүн холбоо болсон байна.



Гурав зурвал Г.АРУУХИЙН

M STRESS

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр 30
Шөнө 14

Нөгөөдөр
Өдөр 31
Шөнө 16

Өдрийн зурхай

**ЗУНЫ ЭХЭН ХӨХӨГЧИН
МОГОЙ САР НАЙМАН
ЦАГААН МЭНГЭТЭЙ
ЦАГААГЧИН МОГОЙ
ӨДӨР**

Наран ургах шингэх: 04.53-20.55
Үс засуулбал: Сүлд тэнж олно



Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлдэг хийхэд эерэг сайн ба баяр, туулай жилтнээ сөрөг туу нөлөөтэй тул элдэв үйлд хяналгай хандаж, бие эвчрүүлжээ. Үсг зурхайд суралцах, бэрийн болон буяны үйл, дайсныг дарахад сайн. Зүүн нүд татвал үзсгэлэн болох, баруун нүд татвал үйл өчүүхэн бүтэх, баруун чих хангинавал гоо болох, зүүн чих хангинавал сайн. Нохой уливал хааны хэрэг болох, хэрэг дуугарвал өөрийн цусыг үзэх, тагнай загатнавал гэрт үзсгэлэн болох, бүх бие татвал эд алдах, хөлийн тах татвал сайн гэдэг. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой.

Г.Ариунбаатар: Монголынхоо

амжилтын шинэ жилсэндээ

маш их баяртай байна



Б.СУМЬЯА

Их Британи, Улард ирландын нэгдсэн вант улсын Уэльсийн нийслэл Кардиф хотноо зохион байгуулагдсан "BBC Cardiff Singer of the World-д тэргүүн байр эзэлж, дэлхийн шилдэг таван дуучны нэгээр тодорсон Чингис хаан одонт, МУЖ Г.Ариунбаатар очигдөр эх орондоо ирлээ. Түүнийг гэр бүлийнхэн болон Төв аймгийн Нутгийн залуучуудын холбоо Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудалд 06.30 цагт угтан авч, хүндэтгэл үзүүлсэн юм. Энэ үеэр түүний сэтгэгдлийг сонслоо.



Юуны өмнө танд баяр хүргэе, дэлхийн дуучин болоод эх орондоо ирж байна, сэтгэгдлээсээ хуваалцаач?

-Нар хур тэгширсэн, сайхан өдөр эх орондоо ирж байна, сайхан байна. "Cardiff singer of the

world" тэмцээнд хоёр төрлөөр оролцож, хоёуланд нь финалд үлдэж, нэг төрөлд нь тэргүүн байр эзэлж, Монголынхоо амжилтыг шинэчилсэндээ маш их баяртай байна. Сэтгэл дүүрэн байна сайхан байна.

-Дэлхийн том дуучид, үзэгчдийн өмнө 'Монголын тал нутаг' хэмээх сайхан дуугаа дуулсан. Энэ нь Монголын үзэгчдэд төдийгүй дэлхий нийтэд маш их таалагдаж, сэтгэлд нь хүрсэн байх?

-Миний хувьд дэлхийн тайзан дээр энэ агуу хөгжмийн зохиолчдын бүтээлийг эгшиглүүлэх юмсан гэсэн мөрөөдөл байсан. Том зориг гаргаж, Монгол сонгодог бүтээлээр хаасан. Олон хүнд их таалагдсан нь мэдэгдэж байлаа. Гадаадад байгаа монголчуудтөдийгүймашолон хүн надад урмын үг хайрлаж, дэмжиж байлаа. Сүүлийн хэдэн өдөр аз жаргалаар бялхсан сайхан өдрүүд байна. Дэлхийн сонгодог бол олон сая хүмүүсийг уйлуулдаг, уяраадаг гайхамшигтай

бүтээл байдаг. Гэхдээ Монгол Улс бас сонгодог урлагтай, бид бас юм бүтээдэг хүмүүс шүү дээ гэдгийг харуулахыг хичээж, тэмцээндээ оролцлоо. Үзэгчид ч маш сайхан хүлээж авсан.

“Cardiff singer of the world”-ийн тайзан дээр тэргүүн байрын шагнал гардаж авах мөчид юу бодогдож байв?

-Мэдээж уралдаанд орж байгаа учраас унах, тэнцэхгүй байх эрсдэл бий. Гэхдээ энэ тэмцээнийг Оросын ард түмэн, маш олон дэлхийн мундаг уран бүтээлчид гээд маш олон хүмүүс харж байгаа учраас өөрийнхөө хүч хөдөлмөрийг шавхах маш том хариуцлага байсан. Тэргүүн байр эзэлсэн мөч бол мэдээж маш сайхан байлгүй яахав. Дэлхийн энэ том тэмцээнд би өөрийгөө сорих, хүч хөдөлмөрөө харуулахаас гадна Монгол Улсынхаа нэрийг гаргаж байгаадаа сэтгэл хангалуун, сайхан байсан.

Таны ойрын төлөвлөгөө юу байна вэ?

-Удахгүй болох баяр наадмынхаа концертод оролцоод, хэд хоног амарна

даа. Тэгээд дараагийн ажилдаа орно. Сая Европын нэлээн томоохон агентуудтай гэрээ байгуулах, цаашдын хамтын ажиллагаа зэргээр ярилцсан. Есдүгээр сараас ажиллаж эхлэх байх.

...Үүний дараа тэрбээр СУИС-д очин багш нартаа хүндэтгэл үзүүлж уг тэмцээнд дуулсан Б.Шаравын ая, З.Түмэнжаргалын үг "Монголын тал нутаг" дуугаа дуулжээ. Энэ үеэр уг дууны хөгжмийг зохиосон төрийн шагналт, хөгжмийн зохиолч Б.Шарав хөгжимдөж хүргэсэн байна. Өчигдөр дэлхийд Монголынхоо нэрийг дуурсгасан залуугийн тухайд шагналын хур буусан өдөр байлаа. "Чингис хаан" одонт, Монгол Улсын гавьяат жүжигчин, цагдаагийн ахмад Г.Ариунбаатар Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар цагдаагийн хошууч цол олгосон юм. Түүнчлэн, СУИС-ийн магистр цол, Цагдаагийн "Сүлд" чуулгын уран сайхны удирдаач болжээ.



ОДДЫН АМЬДРАЛ

СКАРЛЕТТ ЙОХАНССОН шинэ найз залуутай болжээ

Холливудын жүжигчин Скарлетт Йоханссон өөрийн өмгөөлөгч Кэвин Йорнтог жиг ургуулсан талаарх мэдээлэл батлагджээ. Энэхүү үйл явдал телевизийн хөтөлгөч Колен Жосттой болсоноос хойш долоо хоногийн дараа болсон байна. Өнгөрсөн бямба гарагт хосууд Нью-Йоркийн нэгэн итали ресторанд оройн зоог барьсны дараа гудамжаар зугаалж яваад папарацци нарын дуранд өртжээ. Тэд гар гараасаа хөтөлцөн явсан нь олон нийтийг Скарлетт болон Кэвин харилцаа нэлээд дотно болсныг илтгэсэн хэрэг болов. Одоогоор 32 настай жүжигчин бүсгүй болон түүний 51 настай өмгөөлөгч нарын талаар тодорхой мэдээлэл хийх нь дэндүү эрт байна.

Гвинет экс нөхөртэйгөө ЭРГЭН НИЙЛЭВ ҮҮ

Холливудын нэрт жүжигчин, "Оскар"-ын шагналт Гвинет Пэлтроу өнгөрсөн 2014 онд нөхөр "Coldplay" хамтлагийн дуучин Крис Мартинаас тусдаа амьдрах болсон билээ. Хос 2015 оны эхээр албан ёсоор салцаасан юм. Тэд 2004 онд хуримаа хийсэн бөгөөд охин, хүүтэй билээ. Салалтын дараа жүжигчин бүсгүй, охидууддаа асран хамгаалах болсон. Тэгвэл орон нутгийн хэвлэлийнхэн Крис, Гвинет нарыг дахин нийлсэн хэмээн мэдээлэх болсон талаар "www.dailymail.co.uk" сайт мэдээллээ. Тэд өчигдөр Канн хотын далайн эрэг дээр амарч байхдаа гэрэл зурагчдын дуранд өртжээ. Крис, Гвинет ихэд дотно байхаас гадна тэдний хүүхдүүд болох 11 настай Мосес, 12 настай Апли нар хамт байжээ. Гэхдээ албан ёсоор уг мэдээллийг хоёр тал батлаагүй байна.

ДУУЛГАХ СОНИН

Наадмын тасалбар 16-24 мянган төгрөгийн үнэтэй

Үндэсний их баяр наадам ирэх сард болно. Үүнтэй холбогдуулан наадмын бэлтгэл ажил үргэлжилж байгаа билээ. Улсын их баяр наадмын Төв цэнгэлдэх хүрээлэнд болох нээлт, хаалт, бөхийн барилдаан тасалбарыг Соёлын төв өргөөнөөс ирэх сарын 07-нд худалдаалахаар болсон билээ.

Тэгвэл тасалбарын үнэ тодорхой болсон байна. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, наадам зохион байгуулах хорооны гишүүн Э.Ганхүү "Наадмын тасалбар 16, 20, 24 мянган төгрөгийн үнэтэй байна" хэмээн мэдээлжээ. Энэ жилийн наадмын төсвийн 1.9 тэрбум төгрөгийг Сангийн яамнаас, 550 сая төгрөгийг нийслэлийн төсвөөс гаргажээ.

Хүчингүйд тооцов

"Бэст прогресс" ХХК улсын бүртгэлийн дугаар 9011295066, регистрийн дугаар 5490847 татан буулгах болсоныг зарлуулав.

Далай овогтой Бөхбаатар Төв аймгийн Сэргэлэн сум зөрлөг дэнгийн ам гэрчилгээний дугаар 18669284229671, улсын бүртгэл 0004502220 тоот бүртгэлтэй 3га талбайтай үйлдвэр, үйлчилгээний зориулалттай эзэмшлийн гэрчилгээ гээгдүүлсэн тул хүчингүй болгов.

МУБИС-г багш шалгаруулж авна

БАГШИЙН СУРГУУЛЬ:	БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:
- Сурган сэтгэл судлалын багш -1 - Хөгжим арга зүйн багш -2	- CV монгол хэлээр - Бакалавр, магистр докторын дипломын баталгаажуулсан хуулбар - Төрийн албан хаагчийн анкет - Ажил байдлын тодорхойлолт - Иргэний үнэмлэхний баталгаажуулсан хуулбар - Цээж зураг 3 хувь /3*4/ - Нийгмийн даатгалын дэвтэр, эрүүл мэндийн дэвтрийн хуулбар - Шалгалтын хураамж 20.000 төгрөг тус тус авч ирнэ үү
БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН СУРГУУЛЬ:	
- Сэтгэл судлалын багш -1	
УРЛАГ, БИЕИЙН ТАМИРЫН СУРГУУЛЬ:	
- Хөгжмийн онолын /гармони/ багш-1 - Найрал дууны багш -1 - Сагсан бөмбөгийн мэргэжлийн багш-1 тус тус шалгаруулж авна.	
ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:	ШАЛГАЛТ: 2017 оны 06 дугаар сарын 26-30-ны өдрүүдэд дараах чиглэлээр явагдана.
Монгол улсын төрийн болон гадаадын их дээд сургуулиудыг магистр болон түүнээс дээш зэрэгтэй төгссөн, ерөнхий боловсролын сургууль болон их дээд сургуулиудад багшилж байсан туршлагатай, судалгааны арга зүй эзэмшсэн, гадаад хэл (англи, орос, болон бусад), сурган хүмүүжүүлэх ухаан, боловсрол судлалын зохих мэдлэгтэй, мэдээлэл харилцааны технологийн хэрэглээний чадвар эзэмшсэн, багаар ажиллах чадвартай, оюутнуудтай харилцах эв дүйтэй, бүтээлч сэтгэлгээтэй, боловсролын шинэчлэлд нээлттэй, тогтвор суурьшилтай ажиллах, багшийн ёс зүйг сахидаг байх.	Үүнд: 1 Эхний ярилцлага 2 Мэргэжлийн шалгалт 3 Гадаад хэл /Англи, орос болон бусад хэл/ 4 Мэдээлэл харилцаа технологийн хэрэглээний чадвар 5 Боловсрол судлалын орчин үеийн асуудлууд 6 Нэгдсэн ярилцлага
Бүртгэл: 2017 оны 06 дугаар сарын 19-23-ныг дуустал МУБИС-ийн 1-р байрны /хуучнаар А байрны/ 108 тоотод явагдана.	Жич: Тухайн шалгалтандаа тэнцээгүй ажил горилогчийг дараагийн шатны шалгалтад оролцуулахгүй бөгөөд хураамжийг буцаан олгохгүй болохыг анхаарна уу
Холбогдох утас: 311547, 99957309 Хөтөлбөрийн нэгдсэн алба	

E-mail: mongoliin_medee@yahoo.com

Утас: 976-70113551

Факс: 976-70113551

Реклам, зар сурталчилгааны алба: 99173710